

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/39/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2023  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал  
Утас:70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn  
Аудитын менежер: О.Амаржаргал  
Утас:70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК  
захирал: С.Оюунгэрэл

Утас: 70117179 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	3
Аудитын гол асуудал.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар .....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	20
5.3 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НББ	Нягтлан бодох бүртгэл



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 4/25  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Л.ПҮРЭВСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цээл сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цээл сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийн хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоосонтой холбоотой мөнгөн хөрөнгийн данс 78,857.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Аудитын гол асуудал**

Цээл сумын эрүүл мэндийн төв нь тусгай зөвшөөрлөөр эргэлтийн эмийн сангаар дамжуулан эм худалдан борлуулах эмийн сангийн үйлчилгээг эрхлэн явуулдаг, эм борлуулсны орлого 120,896.3 мянган төгрөг цахим баримтад илүү шивэгдсэн байна.

019020119

Эргэлтийн эмийн сан нь байрны түрээсийн төлбөр, түрээсийн орлого төсөвт төвлөрүүлээгүй, төсвөөс байр ашиглалтын төлбөр, эм зүйчийн цалин хөлс, шимтгэл, гэрэл цахилгаан, дулаан, ус, хог, тээвэр, шатахууныг зарцуулж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Нийгмийн эрүүл мэндийн ажлын хүрээнд 3 хөтөлбөрийн хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж эрүүл мэндийн газраар 98,8 хувьтай дүгнэгдсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>95,864,233.32</u></b>	<b><u>144,896,024.65</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	22,875,075.38	78,857,442.16
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	22,875,075.38	78,857,442.16
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	22,875,075.38	78,857,442.16
31211	Төрийн сангийн харилцах	22,875,075.38	78,857,442.16
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	4,207,089.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	4,207,089.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	72,989,157.94	61,831,493.49
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	41,064,501.20	26,064,933.60
35130	Эм боох материал	41,064,501.20	26,064,933.60
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	31,924,656.74	35,766,559.89
35410	Бичиг хэргийн материал	1,054,500.00	791,500.00
35420	Аж ахуйн материал	1,204,000.00	614,000.00
35460	Хүнсний материал	3,468,075.00	2,795,394.00
35470	Бусад хангамжийн материал	26,198,081.74	31,565,665.89
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>519,988,809.67</u></b>	<b><u>512,200,409.05</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	519,988,809.67	512,200,409.05
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	503,058,559.82	495,323,909.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	334,496,891.28	334,496,891.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	(38,206,790.88)	(47,758,488.60)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	76,602,143.00	75,062,143.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(22,607,381.04)	(36,141,095.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	144,198,462.01	179,915,086.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	(33,208,588.27)	(55,228,273.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,104,534.96	57,067,644.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,229,792.51)	(13,936,969.62)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,236,000.00	2,236,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(326,918.73)	(389,029.89)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	16,930,249.85	16,876,500.00
39301	Програм хангамж	530,000.00	530,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(453,750.15)	(507,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,854,000.00	16,854,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>615,853,042.99</u></b>	<b><u>657,096,433.70</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>4,088,585.15</u></b>	<b><u>4,524,616.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	4,088,585.15	4,524,616.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	4,088,585.15	4,524,616.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,088,585.15	4,524,616.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>611,764,457.84</u></b>	<b><u>652,571,817.70</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	611,764,457.84	652,571,817.70

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	93,806,679.93	93,806,679.93
51101	Өмч: - төрийн	93,806,679.93	93,806,679.93
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>258,620,898.16</b>	<b>299,428,258.02</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	248,497,322.04	258,620,898.16
51220	Тайлант үеийн үр дүн	10,123,576.12	40,807,359.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	259,336,879.75	259,336,879.75
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>615,853,042.99</b>	<b>657,096,433.70</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>613,177,952.64</b>	<b>682,526,692.24</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>98,616,462.64</b>	<b>51,039,745.18</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	98,616,462.64	51,039,745.18
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	98,616,462.64	51,039,745.18
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	98,616,462.64	50,039,745.18
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>514,561,490.00</b>	<b>631,486,947.06</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	30,371,600.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	30,371,600.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	250,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	37,751,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	37,751,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	483,939,890.00	593,735,647.06
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	483,939,890.00	593,735,647.06
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>602,497,604.43</b>	<b>641,205,999.10</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>602,497,604.43</b>	<b>641,205,999.10</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	595,088,218.43	641,205,999.10
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	276,822,899.86	360,091,920.00
210101	Үндсэн цалин	267,095,905.01	360,091,917.00
210102	Нэмэгдэл	5,778,449.85	3.00
210104	Урамшуулал	3,948,545.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	39,109,109.18	46,425,518.28
210201	Тэтгэврийн даатгал	28,927,030.18	32,327,565.28
210202	Тэтгэмжийн даатгал	2,886,847.00	3,798,921.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,222,115.00	2,933,538.00
210204	Ажилгүйдлийн даатгал	461,193.00	649,619.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,611,924.00	6,715,875.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	33,310,185.15	36,692,330.85
210301	Гэрэл, цахилгаан	3,105,642.15	4,099,900.00

210302	Түлш, халаалт	29,859,543.00	32,592,430.85
210303	Цэвэр, бохир ус	345,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>33,093,563.00</b>	<b>29,671,175.00</b>
210401	Бичиг хэрэг	3,000,200.00	2,552,600.00
210402	Тээвэр, шатахуун	23,823,563.00	21,968,275.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,166,800.00	1,362,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	411,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,897,500.00	3,788,000.00
210408	Бараа материал акталсны зардал	794,000.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>111,121,798.50</b>	<b>92,842,446.28</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,441,868.50	80,946,475.28
210502	Хоол, хүнс	10,679,930.00	11,895,971.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,912,000.00</b>	<b>-</b>
210604	Урсгал засвар	12,912,000.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,587,500.00</b>	<b>2,643,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,587,500.00	2,643,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>-</b>	<b>1,326,088.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	575,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	427,088.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>86,131,162.74</b>	<b>71,513,220.69</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,874,282.00	18,558,418.85
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,256,880.74	52,954,801.84
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,409,386.00</b>	<b>-</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,409,386.00</b>	<b>-</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,409,386.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>10,680,348.21</u></b>	<b><u>41,320,693.14</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>556,772.09</b>	<b>513,333.28</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	556,772.09	513,333.28
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(556,772.09)</b>	<b>(513,333.28)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>10,123,576.12</u></b>	<b><u>40,807,359.86</u></b>

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	103,831,800.00	59,393,490.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	91,731,800.00	48,170,200.00
210502	Хоол, хүнс	11,000,000.00	11,223,290.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,100,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	38,514,200.00	4,930,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,007,500.00	1,130,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	19,000,000.00	3,200,000.00
210604	Урсгал засвар	16,506,700.00	600,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,587,500.00	2,643,300.00
210702	Дотоод албан томилолт	2,587,500.00	2,643,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	1,326,088.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	575,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	427,088.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	36,528,700.00	9,774,490.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,528,700.00	9,774,490.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,409,386.00</b>	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	7,409,386.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,409,386.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>77,545,534.96</u></b>	<b><u>80,205,276.78</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>56,560,200.00</b>	<b>24,222,910.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>56,560,200.00</b>	<b>24,222,910.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	56,560,200.00	24,222,910.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	56,560,200.00	24,222,910.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(56,560,200.00)</u></b>	<b><u>(24,222,910.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	20,985,334.96	55,982,366.78
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	1,889,740.42	22,875,075.38
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	22,875,075.38	78,857,442.16

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	93,806,679.93	259,336,879.75	248,497,322.04	601,640,881.72
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>93,806,679.93</b>	<b>259,336,879.75</b>	<b>248,497,322.04</b>	<b>601,640,881.72</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	10,123,576.12	10,123,576.12
C08	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>93,806,679.93</b>	<b>259,336,879.75</b>	<b>258,620,898.16</b>	<b>611,764,457.84</b>
D01	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>93,806,679.93</b>	<b>259,336,879.75</b>	<b>258,620,898.16</b>	<b>611,764,457.84</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>93,806,679.93</b>	<b>259,336,879.75</b>	<b>258,620,898.16</b>	<b>611,764,457.84</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	40,807,359.86	40,807,359.86
D09	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>93,806,679.93</b>	<b>259,336,879.75</b>	<b>299,428,258.02</b>	<b>652,571,817.70</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	693,067,700.00	572,297,491.28	120,770,208.72	82.57
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	693,067,700.00	572,297,491.28	120,770,208.72	82.57
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	693,067,700.00	572,297,491.28	120,770,208.72	82.57
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	465,711,800.00	365,550,044.54	100,161,755.46	78.49
210101	Үндсэн цалин	264,491,700.00	244,607,379.24	19,884,320.76	92.48
210102	Нэмэгдэл	118,225,700.00	84,081,146.30	34,144,553.70	71.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,880,800.00	4,390,000.00	(509,200.00)	113.12
210104	Урамшуулал	79,113,600.00	32,471,519.00	46,642,081.00	41.04
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	56,979,900.00	40,967,393.74	16,012,506.26	71.90
210201	Тэтгэврийн даатгал	38,746,500.00	28,604,385.12	10,142,114.88	73.82
210202	Тэтгэмжийн даатгал	4,558,800.00	3,335,952.46	1,222,847.54	73.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,647,300.00	2,567,565.06	1,079,734.94	70.40
210204	Ажилгүйдлийн даатгал	910,900.00	567,253.09	343,646.91	62.27
210205	Эрүүл мэндийн даатгал	9,116,400.00	5,892,238.01	3,224,161.99	64.63
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,601,300.00	36,601,300.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	4,099,900.00	4,099,900.00	-	100.00
210302	Түлш, халаалт	32,156,400.00	32,156,400.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	345,000.00	345,000.00	-	100.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	30,429,500.00	26,888,475.00	3,541,025.00	88.36
210401	Бичиг хэрэг	1,832,900.00	1,832,900.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	25,509,300.00	21,968,275.00	3,541,025.00	86.12
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,362,300.00	1,362,300.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,725,000.00	1,725,000.00	-	100.00
2105	<b>Нормативт зардал</b>	60,174,500.00	59,393,490.00	781,010.00	98.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	48,170,300.00	48,170,200.00	100.00	100.00
210502	Хоол, хүнс	12,004,200.00	11,223,290.00	780,910.00	93.49
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	23,443,100.00	23,443,100.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	13,000,000.00	-	100.00
210602	Тавилга	6,093,100.00	6,093,100.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,200,000.00	3,200,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	1,150,000.00	1,150,000.00	-	100.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,643,300.00	2,643,300.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	2,643,300.00	2,643,300.00	-	100.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,600,000.00	1,326,088.00	273,912.00	82.88
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00	-	100.00

210803	Даатгалын үйлчилгээ	670,000.00	575,000.00	95,000.00	85.82
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	-	100,000.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	506,000.00	427,088.00	78,912.00	84.40
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	15,484,300.00	15,484,300.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,484,300.00	15,484,300.00	-	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	846,681,400.00	627,279,858.06	219,401,541.94	74.09
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	215,240,100.00	37,751,300.00	177,488,800.00	17.54
122005	Орон нутгийн төсвөөс	215,240,100.00	37,751,300.00	177,488,800.00	17.54
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	631,441,300.00	589,528,558.06	41,912,741.94	93.36
122001	Хандив тусламж /дотоод/	631,441,300.00	589,528,558.06	41,912,741.94	93.36
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	22,875,075.38	(22,875,075.38)	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	78,857,442.16	(78,857,442.16)	-

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Анх 1977 оны 8 дугаар сард Угтаалцайдам сумын Цээлийн тасгийн бага эмчийн салбарт түшиглэн 5 гэр 8 ажилтантайгаар 55,384 төгрөгийн үндсэн хөрөнгөтэй 10 ортой байгуулагдсан түүхтэй.

Байгууллагын зорилго нь сумын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартын шаардлагыг хангах нөхцөлийг бүрдүүлэх цээл хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн суурь, тусламж үйлчилгээний тэгш байдал, хүртээмж чанарыг сайжруулахад оршино. Зорилт нь Сумын эмнэлгийн дэд бүтцийг сайжруулж, санхүүжилтыг оновчтой болгосноор сумын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл хангагдана гэжээ.

Цээл сумын эрүүл мэндийн төв нь сумын хүн амыг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх арга ажиллагаанд сургах, бие бялдрын өв тэгш хөгжлийг хангаж, эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй, жигд хүртээмжтэй, чанартай үзүүлэхэд мэргэжлийн үйлчилгээ явуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Зорилт нь:

- ✓ Үйлчлүүлэгчээ дээдэлнэ.
- ✓ Эмнэлгийн эмч, мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахина.
- ✓ Хариуцлага хүлээх ёстой: Сумын ард түмний эрүүл мэндийн төлөө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлж ажиллана.
- ✓ Шударга ёс: Төрийн хууль ёс, хэм хэмжээг чанд сахиж, албан үүргээ үнэнч шударгаар биелүүлнэ.
- ✓ Найдвартай байдал: Мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангаж, багаар ажиллан эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай үзүүлнэ.

Цээл сумын эрүүл мэндийн төвийн чиг үүргийг эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх; сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх, сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх гэж тодорхойлсон.

2021-2023 онуудад эрүүл мэндийн төв нь нийт 2072 иргэнийг хэвтүүлэн эмчилж 14423 ор хоног ашигласан.

Нийт 2765 хүн амаас урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан 1982 хүн, үүнээс хүүхэд 945, том хүн 1786 байна. Хамрагдалт 72 хувьтай байна.

Байгууллага хамт олны санаачилгаар эмнэлгийн хашаанд 50 ширхэг чацарганы мод, 12 ширхэг шинэс мод, агч мод 8 ширхэг, шар хуас 10 ширхэг, улиас 15 ширхэг, тарьж зүлэгжүүлсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Цээл сумын эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д “Хот суурийн газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” үзүүлдэг Эрүүл мэндийн сайдын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд доорх өөрчлөлт орсон байна.

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Эрүүл мэндийн тухай хууль
- ✓ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль
- ✓ Зөвшөөрлийн тухай хууль
- ✓ Эм, эмнэлгийн хэрэглэлийн тухай хууль
- ✓ Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ
- ✓ Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамрах албан тушаалын жагсаалт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цээл сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Цээл сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 41,243.4 мянган төгрөгөөр буюу 6,7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	22,875.08	78,857.44	55,982.37
Авлага	-	4,207.09	4,207.09
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	72,989.16	61,831.49	(11,157.66)
Үндсэн хөрөнгө	519,988.81	512,200.41	(7,788.40)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>615,853.04</b>	<b>657,096.43</b>	<b>41,243.39</b>
Өр төлбөр	4,088.59	4,524.62	436.03
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	93,806.68	93,806.68	-
Хуримтлагдсан үр дүн	258,620.90	299,428.26	40,807.36
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	259,336.88	259,336.88	-
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>615,853.04</b>	<b>657,096.43</b>	<b>41,243.39</b>

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн данс 55,982.3 мянган төгрөгийн өөрчлөлттэй байгаа нь хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх болсноор жилийн эцэст зарцуулагдаагүйтэй холбоотой мөнгөн хөрөнгийн данс 78,857.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын дансны үлдэгдэл 4,207.0 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авлагатай гарч тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Бараа материал 11,157.6 мянган төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн материал, сэлбэг хэрэгсэл, аж ахуйн материал, эм боох материал, түлш шатах тослох материал зэрэг үлдэгдэлтэй байсан хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 7,788.4 мянган төгрөгөөр буурсан нь элэгдэл, 1,500.4 мянган төгрөгийн мотоцикл акталсантай холбоотой.

Өр төлбөрийн данс 2023 оны эхэнд түлш халаалтын өглөг 4,088.5 мянган төгрөг байснаас тайлант хугацаанд халаалтын үнийн өсөлтөөс болж жилийн эцэст түлш халаалтын зардалд 4,524.6 мянган төгрөгөөр байгууллагад төлөх өглөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 39,536.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 541,925.6 мянган төгрөг, нийт зарлагыг 581,461.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас 7,898.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 589,359.6 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 473,536.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 157,904.4 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 37,751.3 мянган төгрөгийг орон нутгийн санхүүжилтээр бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр 461,254.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 128,274.4 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 37,751.3 мянган төгрөгийг орон нутгийн санхүүжилтээр төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 534,546.2 мянган төгрөг буюу 81,6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлаас цалин хөлс 58,194.6 мянган төгрөгийг, нэмэгдэл унаа хоол, шатахуун, шимтгэл, нэмэгдэл урамшууллыг 62,575.5 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Биелэлт
80302- Нэг иргэнд ноогдох нормативаар	473,536.90	415,342.27	58,194.63	87,7
81603-Үндсэн тусламж үйлчилгээ	157,904.40	95,328.92	62,575.48	60,3
83601-Нэмэлт олон улсын байгууллагаас олгосон	1,000.00	1,000.00	0.00	100,0
83603 -Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	22,875.10	22,875.10	0.00	100,00

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 3 хөтөлбөрийн 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Хэрэгжилтийг 90 хувьтай биелүүлэн ажилласан байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа бичиг хэргийн материал 1,832.9 мянган төгрөг, тээвэр шатахуун 20,968.2 мянган төгрөг, хоол хүнс 11,223.2 мянган төгрөг, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл 48,170.2 мянган төгрөг, багаж техник хэрэгсэл 13,000.0, тавилга 6,093.1 мянган төгрөг нийт 13 ажил үйлчилгээний 124,221.3 мянган төгрөгийн төлөвлөгөө батлуулснаас 119,899.4 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Цээл сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ийн аудитор Я.Оюун, Шинжээч Ц.Цацрал, Х.Ариунжаргал нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Цээл сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 613,177.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 9,197.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,898.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг авч ажилласнаар цалин хөлсний зардлыг 19,884.3 мянган төгрөгөөр, тээвэр шатахууныг 3,541.0 мянган төгрөгөөр хэмнэн ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

4.4.1.1 Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлэх 159 мэдээллээс 154 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцорсон 1 мэдээлэл, 4 мэдээлэл байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг мөрдөн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

4.4.2.1 Улсын бүртгэлийн гэрчилгээнд хөрөнгийн хэмжээ 38,768.7 мянган төгрөг, санхүү байдлын тайлан дээр төрийн өмч 93,803.7 мянган төгрөг буюу 55,037.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь санхүүгийн тайланд тусгагдсан ажил гүйлгээ буюу үйл явдал, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэдээллийг үнэн зөв баталгаажуулах, бүртгэлдээ өөрчлөлтийг оруулдаг байх зөвлөмж хүргүүлэв.

4.4.2.2 Мөнгөн хөрөнгийн түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зарцуулалт гаргах, эм бараа, түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны 120,896.3 мянган төгрөгийн цахим баримт илүү шивэгдсэн баталгаажуулах, тооллогоор 16 хайрцаг эм, эмийн бүтээгдэхүүн хугацаа дууссан эмнэлгийн эмийн сангийн өрөөнд хадгалагдсан байдалтай байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх

4.4.2.3 Төв аймгийн эрүүл мэндийн газраас эмийн сангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон, Цээл сумын эрүүл мэндийн төвийн улсын бүртгэлийн гэрчилгээ дүрэмд эрхлэх үйл ажиллагаагаар бүртгэгдээгүй байгаа нь зөвшөөрлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн нийтлэг шаардлагад 1.1-д “иргэний эрх зүйн бүрэн чадамжтай байх”, 1.2-т “хуульд заасан бол мэргэжил, мэргэшлийн шалгалтад тэнцсэн, зохих дүгнэлт гаргуулсан байх”, 1.3-д “татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх”, 2-т “Зөвшөөрөл эзэмшигч дараах үүрэг хүлээнэ”, 2.1-д “хуульд заасан баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэх”, 2.2-т “тухайн үйл ажиллагааг эрхлэх хуулиар тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах”, 2.3-д “хуулиар хориглосон, эсхүл хязгаарласан тохиолдолд зөвшөөрөлд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхгүй байх”, 2.4-д “хуульд өөрөөр заагаагүй бол зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг байнга эрхлэн явуулах”, 2.5-д “зөвшөөрлийг эрх бүхий этгээдээс авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ тухай татварын албанд мэдэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлэх”, 2.6-д, 3 дугаар бүлгийн 3.2.2-т заасан хуульд заасан зарчмыг баримтлах, 2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд зөвшөөрөл олгох гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх

4.4.2.4 Цээл сумын эрүүл мэндийн төв нь тусгай зөвшөөрлөөр эм худалдан борлуулах эмийн сангийн үйлчилгээг давхар эрхлэн явуулдаг, эргэлтийн эмийн сан нэртэй эрхзүйн чадамжгүй, сан нь үйл ажиллагаа явуулахдаа байрны түрээсийн төлбөр төлдөггүй түрээсийн орлого төсөвт төвлөрүүлээгүй, төсвөөс байр ашиглалтын төлбөр, эмийн сангийн эм зүйчийн цалин хөлс, шимтгэл, гэрэл цахилгаан, дулаан, ус, хог, тээвэр, шатахууны төлбөрийг төлж байгаа нь Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 20 дугаар зүйлд захирлын эрх үүрэгт 20.5-д “Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна”, 21 дүгээр зүйлд “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно” гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Татварын тухай, Төсвийн тухай, Улсын бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Зөвшөөрлийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

## **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар анхан шатны и-баримтын бүрдэл, Засгийн газар оролцоо сангийн бүртгэл, цалинтай холбоотой бүртгэл, шилэн дансны мэдээлэл, бичиг хэрэг хөтлөлт, өглөгийн данстай холбоотой бүртгэл, эмийн эргэлтийн сантай холбоотой нийт 5 зөвлөмж хүргүүлснээс 2 зөвлөмж 100 хувь хэрэгжүүлэн ажилласан, 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1		0	0	0
Зөвлөмж	1	300.0	1	300.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>300.0</b>	<b>1</b>	<b>300.0</b>	<b>50.0</b>

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 300.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс шилэн дансны албан шаардлага хэрэгжээгүй, 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эмийн эргэлтийн сан нь байрны түрээсийн төлбөр төлдөггүй, хувь хүн иргэдэд олгосон цахим баримтыг байгууллагын регистрээр шивдэг, ашиглалтын зардал төлөхгүй байгаа асуудлыг авч үзэх, нормативт зардлын гүйцэтгэлийг давтан хянах, худалдан авалт хийхдээ үнийн харьцуулалт хийдэг эсэх, албан бичгээр харилцдаг эсэхийг авч үзэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар илэрсэн 17.7 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүллээ.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Өглөгийн данстай хөлбөөтэй

Өглөг

Татварын цахим тайлангийн системээр Авто тээвэр, өөрөө явагч хэрэгсэл, Автын агаарын бохирдол, газрын төлбөр нийт 17.7 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж (Орлогын алдаагүй, үний зөв бүртгэл хөтөлж олж зөвлөмж өгөв.)

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Татварын цахим тайлангийн системээр Авто тээвэр, өөрөө явагч хэрэгсэл, Автын агаарын бохирдол, Газрын төлбөр нийт 17.7 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй байна.							1	17.7				
Дүн							1	17.7				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцорсон 1 мэдээлэл, мэдээлээгүй 4 мэдээлэл байна.	1	0			1	0		
Дүн	1	0			1	0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Засгийн газрын оролцоо сан 55,037.9 төгрөгөөр зөрүүтэй байна.	1	55,037.9					1	55,037.9
Үйл ажиллагааны зарцуулалт гаргах, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримт 120,896.3 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн байна.	1	120,896.3					1	120,896.3
Эм худалдан борлуулах эмийн сангийн үйлчилгээг давхар эрхлэн явуулдаг	1						1	
Түрээсийн орлого ашиглалтын төлбөр, эмийн сангийн эм зүйчийн цалин хөлс, шимтгэл, гэрэл цахилгаан, дулаан, ус, хог, тээвэр, шатахууны төлбөрийг зориулалт бусаар зарцуулсан	1						1	
Дүн	4	175,934.3					4	175,934.3
Нийт дүн	5	175,934.3			1	0	4	175,934.3



ТӨВ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 27-14570576-ТВА-2024/

Зуунмод

39/НА-ЕТА-ТВС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цээл сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар шилэн дансанд хугацаа хоцорсон 1 мэдээлэл, мэдээлээгүй 4 мэдээлэл байршуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх,"; 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:"; 6.4.4-д"таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд ил тод, бүрэн байршуулах зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх;

<sup>1</sup>Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040119

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг<sup>2</sup> Цээл сумын эрүүл мэндийн төвийн дарга Л.Пүрэвсүрэн, нягтлан бодогч Л.Батчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

  
/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

  
/С.ОЮУНГЭРЭЛ/



<sup>2</sup>Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)